



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/67

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, сүм хийдийн хурал, цуглаан, үзэсгэлэн худалдаа, караоке, аялал зугаалгын арга хэмжээ зохион байгуулахыг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

2. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа иргэдийн PCR шинжилгээг сайтар нягтлан 72 цаг өнгөрсөн, шинжилгээний хариу www.119.mn, eruul.gerege.mn цахим сайтад хүлээлгийн горимд байгаа гэсэн өгүүлэмжтэй иргэдийг нэвтрүүлэхгүй байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Голомтын бүс нутгаас эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмчийн 13А маягт, ар гэрийн гачигдлаар ирэх иргэдээс бусад иргэдийг хүлээн авахгүй байж дээрх тохиолдлоор ирсэн иргэдийн гэрийн ажиглалтад байх хугацаанд тавих хяналтыг сайжруулж, мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2, 5, 9 дүгээр ангийн сурагчдын сургалтын агуулгын хоцрогдлыг арилгах Улсын болон чанарын үнэлгээний шалгалтад бэлтгэх зорилгоор танхимын давтлагыг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эхлүүлсүгэй.

6. Давтлага зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (А.Мөнхтуяа), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг

481210169

Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

7. Захирамжийг хэрэгжүүлж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ